



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах  
тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь :

1. “Улаан бурханы өвчлөлийг таслан зогсоох стратеги”-ийн хэрэгжилтэд төгсгөлийн үнэлгээг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үнэлгээний дүнг 2015 оны 06 дугаар сард удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Оюунсүрэн/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д даалгасугай.



САЙД

Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080527

Эрүүл мэнд, Спортын сайдын  
2015 оны 04 сарын 21-өдрийн  
452 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: Э.Оюунсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын /ХШУДАГ/ даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Нарийн бичгийн дарга: Р.Байгалмаа, ХШУДАГ-ын мэргэжилтэн
- Гишүүд:
- Д.Нарангэрэл, Эрүүл мэнд, спортын яамны Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
  - С.Амарзаяа, ХШУДАГ-ын мэргэжилтэн
  - Г.Базархүрэл, ХШУДАГ-ын мэргэжилтэн
  - Г.Сүрэнханд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дэд дарга
  - Б.Нарантуяа, Дархлаажуулалтын сан хариуцсан мэргэжилтэн
  - Ж.Оюунбилэг, Монголын вирус судлалын нийгэмлэгийн дэд тэргүүн /зөвшилцсөнөөр/
  - Б.Цэцэгсайхан, ДЭМБ-ын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, Спортын сайдын  
2015 оны 04 сарын 21-өдрийн  
152 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

**“УЛААНБУРХАНЫ ӨВЧЛӨЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ СТРАТЕГИ”-ИЙН  
ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ.**

**Үндэслэл:**

Монгол улсын дархлаажуулалтын тухай хууль, “Улаанбурхан өвчнийг таслан зогсоох стратеги” батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2012 оны 57 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах

**Зорилго:**

“Улаан бурхан өвчнийг таслан зогсоох стратеги”-ийн төгсгөлийн үнэлгээ, дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж дэвшүүлэх

**Үйл ажиллагааны чиглэл:**

“Улаанбурхан өвчнийг таслан зогсоох стратеги”-ийн төгсгөлийн үнэлгээг дараах чиглэлээр гүйцэтгэнэ.

- Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Стратегийн шалгуур үзүүлэлтийн биелэлт
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан холбогдох эрх зүйн шийдвэрүүдийн биелэлт
- Хамтран ажилласан байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа
- Нэмэлт шаардлагатай мэдээллүүдийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна.

Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллаганы төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэд үнэлгээ өгнө.

Үйл ажиллагааны тайлантай танилцаж, холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад очиж газар дээр нь стратегийн хэрэгжилттэй танилцана.

**Хамрах хүрээ:**

- Халдварт өвчин судлах үндэсний төв,
- Дархлаажуулалтын алба,
- Сонгогдсон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, өрх, сумын эрүүл мэндийн төв,

**Ажиллах бүрэлдэхүүн:**

Эрүүл мэнд, спортын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтэс, эмнэлгийн тусламжийн хэлтэс, эм эмнэлгийн хэрэгслэлийн хэлтэс, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Дархлаажуулалтын алба

**Зохион байгуулагч:**

Эрүүл мэнд спортын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

**Хугацаа:**

2015 оны 4, 5,6 дугаар сар

**Санхүүжилт:**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэнд, спортын яам

**Хүрэх үр дүн:**

Улаан бурхан өвчнийг таслан зогсоох стратегийн төгсгөлийн үнэлгээний дүн гарч, дүнг Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

